



ИЗРАИЛЫГ ЦУГЛУУЛАХ АЖИЛ ДАХЬ ЭГЧ НАРЫН ОРОЛЦОО

Ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсон

Би Сүмийн эмэгтэйчүүд та нарт хандан, тараагдсан Израилыг цуглуулахад тусалснаар ирээдүйн зүг чигийг тодорхойлох бошиглолын гуйлтыг түгээж байна.



Эрхэм хайрт эгч нар аа, та нартай хамт байгаа маань гайхалтай хэрэг юм. Саяхны нэгэн үйл явдал миний та нарын талаар болон та нарт оногдсон бурханлаг чадварыг юу гэж бодож явдаг талаар ойлголт өгөх байх.

Нэг өдөр би Өмнөд Америкийн цугларагсад үг хэлж байхдаа сэдэвтээ автагдан, сэтгэл маш их сэтгэл хөдөлсөндөө тэр торгон мөчид “10 хүүхдийн *ээжсийн* хувьд би үүнийг хэлж байна” гэж хэлээд, захиасаа цааш үргэлжлүүлсэн гэдэг.

Би ээж гэдэг үг хэрэглэснээ анзаараагүй байсан. Орчуулагч маань намайг андуурсан гэж бодоод, ээжийг

аав болгон өөрчилсөн учраас цугларагсад ээж гэж хэлснийг минь мэдээгүй өнгөрчээ. Харин миний эхнэр Вэнди үүнийг сонссон байсан ба дотоод сэтгэлээ илчлэн халтирч хэлсэн үгэнд минь баясаж байлаа.

Тэр мөчид зөвхөн эх хүнийхтэй л адил, дэлхий дээр өөрчлөлт хийх зүрхний минь чин хүсэл ундран гарсан нь тэр байв. Олон жилийн турш хүмүүс надаас яагаад эмч *болсныг* минь асуух болгонд би “Би ээж байхыг сонгож чадахгүй учраас” гэж хариулдаг байв.

Би ээж гэдэг үгийг хэрэглэх бүрдээ зөвхөн энэ амьдралдаа хүүхэд төрүүлж эсвэл өргөж авсан эмэгтэйчүүдийг хэлээгүйг ойлгоно уу. Би Тэнгэрлэг Эцэгийнхээ насанд хүрсэн *бүх* охидын талаар ярьж байна. Эмэгтэй хүн бүр

мөнхийн тэнгэрлэг хувь тавилангийнхаа ачаар эх хүн байдаг юм.

Тиймээс би өнөө орой арван хүүхэдтэй буюу *есөн охин*, нэг хүүтэй *эцэг хүний* хувьд, түүнчлэн Сүмийн ерөнхийлөгчийн хувьд та нарыг болон та нарын хэн болохыг мөн та нарын хийж чаддаг бүхнийг хэчнээн сайн ойлгодог болохыг минь мэдээсэй хэмээн залбирч байна. Хэн ч зөв шударга эмэгтэйн хийдэг зүйлсийг хийж чадахгүй. Хэн ч эх хүний нөлөөг орлож чадахгүй.

Эрэгтэйчүүд Тэнгэрлэг Эцэгийн болон Аврагчийн хайрыг бусдад дамжуулж чаддаг бөгөөд үүнийг үе үе харуулдаг. Харин эмэгтэйчүүдэд үүний онцгой бэлэг болох тэнгэрлэг хишиг өгөгдсөн байдаг. Хэн нэгэнд юу хэрэгтэй байгааг мөн хэзээ хэрэгтэй байгааг мэдэх чадвар та нарт бий. Та нар яг хэрэгтэй үед нь бусдад хүрч, тайтгаруулж, зааж, хүчирхэгжүүлж чаддаг.

Эмэгтэйчүүд аливаа зүйлийг эрэгтэйчүүдээс өөрөөр хардаг бөгөөд та нарын үзэл бодол бидэнд хэчнээн их хэрэгтэй билээ! Та нарын төрөлх чанар эхлээд бусдыг бодоход мөн аливаа үйлдлийг бусдад хэрхэн нөлөөлөх талаас нь авч үзэхэд хүргэж байдаг.

Ерөнхийлөгч Айрингийн цохон тэмдэглэснээр Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөний алсын харааг ойлгон, бидний мэдэх “Уналт”-ын эхний алхмыг хийсэн нэг нь бидний эрхэмсэг Ева эх маань байв. Түүний ухаалаг, зоригтой сонголт Адамын дэмжсэн шийдвэрийн тусламжтайгаар Бурханы аз жаргалын төлөвлөгөөг урагшлуулсан билээ. Тэд бидний хүн нэг бүрд дэлхий дээр ирж, бие махбодтой болох мөн мөнх бус амьдралд сонгосон шигээ одоо Есүс Христийн талд зогсох сонголтыг хийнэ гэдгээ батлан харуулах боломжийг олгосон юм.

Хүндэт эгч нар аа, та нарт онцгой сүнслэг бэлэг, авьяас чадварууд бий. Би өнөө орой та бүхнээс зүрхнийхээ бүхий л найдвараар *өөрсдийн сүнслэг бэлгүүдийг* хэзээ хэзээнээс илүү ойлгож, тордож, ашиглаж мөн хөгжүүлэхээр залбирч үзэхийг гуйж байна. Та нар үүнийг хийснээр дэлхийг өөрчлөх болно.

Эмэгтэй хүний хувьд та нар бусдыг урамшуулан өдөөж мөн даган дуурайх үнэ цэнтэй жишгийг тогтоож байдаг. Өнгөрсөн Ерөнхий чуулганаар зарлагдсан томоохон хоёр зарын талаар товч танилцуулахыг надад зөвшөөрнө үү. Хайрт эгч нар аа, та нар энэ хоёр зарын аль алинд нь чухал үүрэг гүйцэтгэсэн.

Эхнийх нь тохинуулал байсан. Тохинууллын хамгийн дээд жишгийг бидний Аврагч, Есүс Христ үзүүлдэг. Эмэгтэйчүүд эрэгтэйчүүдийг бодвол энэ жишигт үргэлж ойр байж ирсэн. Та үнэн сэтгэлээр тохинуулж байхдаа хэн нэгэнд Аврагчийн хайрыг илүү их мэдрэхэд нь туслахын тулд мэдрэмжээ дагаж байдаг. Тохинуулах мэдрэмжийг зөв шударга эмэгтэйчүүдэд заяадаг юм. “Намайг өнөөдөр хэнд туслаасай гэж хүсэж байна вэ?” гэж өдөр бүр залбирдаг эмэгтэйчүүдийг би мэднэ.

2018 оны 4-р сарын Ерөнхий чуулган дээр бусдад илүү дээр, илүү ариун арга замаар анхаарал тавих талаар

зарлахаас өмнө зарим эрэгтэй гэрийн багшлалтын үүрэгт ажлаа “хийсэн” гэж тэмдэглээд, дараагийн даалгавар руугаа шилжих хандлагатай байсан.

Харин *та нар* айлчилж очсон эгчид тань тусламж хэрэгтэйг мэдсэн бол тэр даруй мөн тэр сарын турш үйлдэл хийдэг байсан. Тиймээс та нарын айлчилж очдог *арга зам* биднийг тохинууллын чанараа дээшлүүлэхэд урамшуулан өдөөсөн билээ.

Хоёрдугаарт, бид өнгөрсөн Ерөнхий чуулган дээр Мелкизедек санваарын чуулгыг дахин зохион байгуулсан юм. Бид Сүмийн эрэгтэйчүүдэд өөрсдийн үүргийг хэрхэн илүү үр дүнтэй гүйцэтгэхэд нь туслах талаар залбирч байхдаа Халамжийн нийгэмлэгийн үлгэр жишээг анхааралтай авч үзсэн.

Халамжийн нийгэмлэгт бүх насны, амьдралын янз бүрийн үе шатанд буй эмэгтэйчүүд цуглардаг. Амьдралын шат бүр өвөрмөц бэрхшээлийг дагуулж байдаг ч та нар долоо хоног бүр цугларч, өсөж хөгжин, сайн мэдээг хамтдаа зааж, дэлхий дээр бодит өөрчлөлтийг бий болгосоор ирсэн.

Одоо Мелкизедик санваартнууд та нарын жишээг даган, ахлагчдын чуулгын гишүүд болсон билээ. Эдгээр ах мөн адил өргөн хүрээг хамарсан санваарын болон Сүмийн туршлагатай 18-аас 98 насны (үүнээс ахмад байж болно) хүмүүс байдаг. Энэ ах нар одоо илүү хүчирхэг ах дүүсийн холбоог үүсгэж, хамтдаа суралцаж, бусдыг илүү үр дүнтэй адисалж чадна.

Өнгөрсөн 6-р сард Нэлсон эгч бид хоёр Сүмийн өсвөр үеийнхэнд хандан үг хэлснийг та нар санаж байгаа. Бид тэднийг хөшигний хоёр талд Израилыг цуглуулахад туслахын тулд Их Эзэний өсвөр үеийнхний батальонд элсэхэд урьсан билээ. Ийн цуглуулах нь “өнөөдөр дэлхий дээрх *хамгийн агуу* үүрэг даалгавар, *хамгийн агуу* учир шалтгаан, *хамгийн агуу* ажил болоод байна”!¹

Энэ бол эмэгтэйчүүдийн хэрэгцээ туйлын чухал болоод байгаа учир шалтгаан юм. Учир нь эмэгтэйчүүд ирээдүйн зүг чигийг тодорхойлдог. Өнөө орой би Сүмийн эмэгтэйчүүд болох та нарт хандан, тараагдсан Израилыг цуглуулахад тусалснаар ирээдүйн зүг чигийг тодорхойлох бошиглолын гуйлтыг хүргэж байна.

Та нар юунаас эхэлж болох вэ?

Би *дөрвөн урилга* өгмөөр байна.

Нэгдүгээрт, би та нарыг олон нийтийн мэдээллийн хэрэгслээс, тухайлбал сөрөг, цэвэр бус бодлыг оюун санаанд тань авчрах мэдээллийн хэрэгслээс татгалзсан арав хоногийн мацагт нэгдэхийг урьж байна. Мэдээллийн хэрэгслээс татгалзан мацаг барьж байх үедээ ямар нөлөөллүүдийг холдуулахаа мэдэж авахын тулд залбир. Арав хоногийн мацгийн тань үр дүн таныг гайхшируулж болох юм. Та Сүнснийг тань шархлуулж байсан дэлхийн ойлголтуудаас түр завсарласны дараа юуг олж анзаарах бол? Одоо таны цаг зав, эрч хүчээ зориулахыг хүсэж байгаа зүйлсэд өөрчлөлт гарсан уу? Таны чухалчилж үздэг зүйлс бага боловч өөрчлөгдсөн үү? Би та нарыг өөрт

төрсөн сэтгэгдлүүдийг нэг бүрчлэн бичиж авч, тэдгээрийг дагахад урьж байна.

Хоёрдугаарт, би та нарыг одооноос эхлээд, энэ ондоо багтаан Мормоны Номыг уншиж дуусгахад урьж байна. Амьдралаа зохицуулах гэж хичээж буй бүхний хажуугаар энэ нь боломжгүй мэт санагдаж болох ч хэрэв та энэ урилгыг зүрх сэтгэлийн дүүрэн зорилготойгоор хүлээн авах юм бол Их Эзэн үүнийг биелүүлэх арга замыг олоход тань туслах болно. Мөн залбирч байгаад судлах юм бол таны дээр тэнгэр нээгдэх болно гэдгийг би амлая. Их Эзэн таныг өсөн нэмэгдэх сүнслэг өдөөлт болон илчлэлтээр адисална.

Би таныг уншиж байхдаа Аврагчийн талаар ярьж, дурдаж буй шүлэг бүрийг тэмдэглэхэд урамшуулж байна. Тэгээд гэр бүл, найз нөхөдтэйгөө Христийн тухай ярьж, Христэд баясаж мөн Христийн талаар номлоход санаачилга гаргаарай.² Та энэ үйл явцаар дамжуулан тэдэнтэй хамт Аврагчид илүү ойртох болно. Өөрчлөлтүүд, бүр гайхамшиг ч тохиолдож эхлэх болно.

Өнөө өглөө ням гаргийн цуглааны шинэ хуваарь болон гэрт төвлөрсөн, Сүмээс дэмжигдсэн хөтөлбөрийн талаар зарласан. Хүндэт эгч нар аа, та нар сайн мэдээг заах энэ шинэ, тэнцвэртэй, уялдаа холбоотой хүчин чармайлтыг амжилттай гүйцэлдүүлэхэд гол үүрэг гүйцэтгэх юм шүү. Судраас сурч мэдэж байгаа зүйлээсээ хайртай хүмүүстээ заагаарай. Нүгэл үйлдсэн үедээ Аврагчийн эдгээгч, цэвэршүүлэгч хүчийг авахын тулд Түүн рүү хэрхэн эргэж очихыг тэдэнд заа. Түүний хүчирхэгжүүлэгч хүчийг хэрхэн өдөр тутмын амьдралдаа татан авч болохыг тэдэнд заа.

Гуравдугаарт, ариун сүмд тогтмол очдог хэвшилтэй бол. Энэ нь амьдралдаа илүү их золиослол гаргахыг шаардаж болох юм. Та ариун сүмд тогтмол очсоноор Их Эзэнд Өөрийнх нь ариун сүм дотор танд өгөгдсөн Түүний санваарын хүчийг хэрхэн ашиглаж болох заах боломжийг олгох болно. Ариун сүмээс хол амьдардаг та нарыг би судраас болон амьд бошиглогчдын үгсээс ариун сүмийн талаар залбирч судлахад урьж байна. Ариун сүмийн талаар урьд өмнөхөөсөө илүү ихийг мэдэж, ойлгож авч, мэдрэхийг хичээгээрэй.

Өнгөрсөн 6-р сард болсон дэлхий даяарх онцгой цуглалалт дээр би эцэг эх нь хүүгийнхээ ухаалаг утсыг энгийн утсаар сольсноор амьдрал нь өөрчлөгдсөн залуу эрэгтэйн тухай ярьсан. Энэ залуу эрэгтэйн ээж итгэл бишрэлтэй эмэгтэй бөгөөд хүү нь номлолд үйлчлэхэд нь саад болж болох сонголтуудад автаж эхэлснийг ойлгожээ. Тэр хүүдээ хамгийн сайнаараа тусалж болох арга замыг олж мэдэхээр ариун сүмд очиж залбирдаг байв. Тэгээд тэрээр өөрт төрсөн бүх мэдрэмжээ дагажээ.

“Хүүгийнхээ утсыг тодорхой зүйлсийг олж мэдэхээр тодорхой цагуудад шалгаж байхад Сүнс намайг удирдаж байгааг би мэдэрсэн. Би эдгээр ухаалаг утсыг хэрхэн

ашиглахыг мэдэхгүй байсан ч Сүнс бүр миний ашиглаж ч мэдэхгүй бүхий л төрлийн олон нийтийн мэдээллийн хэрэгслийг хэрхэн үзэхэд намайг чиглүүлж байсан юм. Хүүхдүүдээ хамгаалахаар удирдамж эрэлхийлж буй эцэг эхчүүдэд Сүнс тусалдаг гэдгийг би мэднэ. Хүү маань [эхэндээ] надад ихэд уурлаж байв. . . . Гэвч ердөө гуравхан хоногийн дараа гэхэд тэр надад талархаж байгаагаа хэлсэн! Тэр өөрчлөлтийг мэдэрч чадсан” гэж тэр хэлсэн.

Хүүгийнх нь зан чанар, хандлага эрс өөрчлөгджээ. Тэрээр гэртээ илүү их тусалдаг болж, илүү их инээмсэглэж, сүмдээ илүү их анхаарал хандуулж байв. Тэр хэсэг хугацаанд ариун сүмийн баптисмын усан санд үйлчилсэн ба номлолд бэлдэхдээ дуртай байсан.

Миний бүх насны эгч нарт өгч буй дөрөв дэх урилга бол Халамжийн нийгэмлэгтээ бүрэн ирцтэй оролцдог байх явдал юм. Би та бүхнийг Халамжийн нийгэмлэгийн одоо баримталж буй зорилгын мэдэгдлийг судлахад уриалж байна. Эндээс бид урам зориг авдаг. Энэ нь та нарыг өөрсдийн амьдралд өөрсдийнхөө зорилгын мэдэгдлийг гаргахад удирдан чиглүүлж болно. Мөн би хориод жилийн өмнө хэвлэгдсэн Халамжийн нийгэмлэгийн тунхаг дээрх үнэнүүдийг шимтэн судлахыг та нараас гуйж байна.³ Энэ тунхгийг жаазлаад, Тэргүүн Зөвлөлийн ажлын өрөөний ханан дээр өлгөсөн байдаг. Үүнийг унших тоолонд миний сэтгэл хөдөлдөг. Энэ нь та нарын хэн болохыг мөн Их Эзэн та нарыг тараагдсан Израилыг цуглуулахад туслахын тулд өөрсдийн үүргийг биелүүлэхдээ энэ тодорхой цаг үед хэн байгаасай гэж хүсэж байгааг тайлбарладаг.

Хүндэт эгч нар аа, та нар бидэнд хэрэгтэй байна! “Бидэнд *та нарын* хүч чадал, *та нарын* хөрвөлт, *та нарын* итгэл үнэмшил, *та нарын* удирдах чадвар, *та нарын* мэргэн ухаан, *та нарын* дуу хоолой хэрэгтэй.”⁴ Бид та наргүйгээр Израилыг цуглуулж огтхон ч чадахгүй.

Би та нарт хайртай бөгөөд талархаж явдаг. Би та нарыг энэ чухал, яаралтай ажилд туслахдаа дэлхийн нөлөөг ардаа орхих чадвараар адисалж байна. Бид Түүний Хайрт Хүүгийн Хоёр дахь ирэлтэд дэлхийг бэлтгэхийн тулд Тэнгэрлэг Эцэгийнхээ биднээс хүссэн бүхнийг хийж чадна.

Есүс бол Христ. Энэ бол Түүний сүм бөгөөд Энэ бүхнийг би Есүс Христийн нэрээр гэрчиллээ, амен.

ЭШЛЭЛҮҮД

1. Ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсон, “Израилийн итгэл найдвар” (Өсвөр үеийнхэнд зориулсан дэлхий даяарх онцгой цуглалалт, 2018 оны 6-р сарын 3).
2. Нифай 25:26-г үзнэ үү.
3. Халамжийн нийгэмлэгийн тунхгийг Mary Ellen Smoot, “Rejoice, Daughters of Zion,” *Liahona*, Jan. 2000, 111-114-р хуудаснаас үзнэ үү.
4. Рассэлл М.Нэлсон, “Эгч нараасаа гуйх гуйлт,” *2015 оны 10-р сарын Ерөнхий чуулган*, 85; тодотгол нэмэгдсэн.

СҮМИЙН ЗӨВ НЭР

Ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсон

Есүс Христ Сүмийг Өөрийнхөө нэрээр нэрлэхэд биднийг чиглүүлж удирдсан, учир нь энэ бол Түүний хүчээр дүүргэгдсэн Түүний Сүм юм.



Хайрт ах, эгч нар минь, энэ үзэсгэлэнтэй сайхан Хүндэтгэлийн өдөр бид Их Эзэнээс ирсэн олон адислалдаа хамтдаа баясаж байна. Бид Есүс Христийн сэргээгдсэн сайн мэдээний тухай та нарын гэрчлэлд болон Түүний гэрээний зам дээр үлдэх юм уу эргэн ирэхийн тулд гаргасан золиослолуудад мөн Түүний Сүмд зориулсан

үйлчлэлийн тань төлөө маш их талархаж байна.

Өнөөдөр би та нартай нэгэн тун чухал асуудлын талаар зайлшгүй ярих ёстой гэж мэдэрлээ. Хэдэн долоо хоногийн өмнө би Сүмийн нэрийг зөв хэлэх тухай нэгэн мэдэгдэл гаргасан билээ.¹ Их Эзэн Өөрийн Сүмийн буюу Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн төлөө илчилсэн нэр хэчнээн чухал болохыг оюун санаанд минь ойгуулан мэдрүүлсэн учраас би үүнийг хийсэн.²

Та нарын хүлээж байсанчлан, энэ мэдэгдэлд болон шинэчлэгдсэн хэв маягийн удирдамжид³ янз бүрийн хариу үйлдэл үзүүлж байна. Олон гишүүн өөрсдийн блог, олон нийтийн сүлжээний хуудсан дээрээ Сүмийн нэрийг тэр даруй засаж бичсэн. Бусад нь дэлхий дээр болж байгаа энэ бүх зүйлийн хажуугаар ямар нэгэн ийм “авцалдаагүй” зүйлийг яагаад онцлох хэрэгтэй гэж? хэмээн гайхсан. Мөн зарим нь огт бүтэхгүй юмыг оролдоод яах ч юм билээ гэж хэлсэн. Бид энэ асуудалд яагаад ийм нухацтай санаа тавих ёстойг би тайлбарлая. Гэвч эхлээд энэ хичээл зүтгэл чухам ямар зүйл *биш* вэ гэдгийг хэлье.

- Энэ бол нэр өөрчилж буй хэрэг *биш* юм.
- Энэ нь худалдааны тэмдэгт шинэчилж байгаа хэрэг биш.
- Энэ бол өнгөлөн далдлалт биш.
- Энэ бол илүү зан гаргаж байгаа хэрэг биш.
- Энэ бол авцалдаагүй зүйл биш.

Харин энэ бол зөв *болгож байгаа* хэрэг юм. Энэ бол Их Эзэний зарлиг. Иосеф Смит сэргээгдсэн Сүмийг өөрөөрөө нэрлээгүй. Мормон ч мөн адил. “Учир нь эцсийн өдрүүдэд миний сүм ийн, бүр Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм хэмээн нэрлэгдэх ёстой”⁴ хэмээн Аврагч Өөрөө хэлсэн билээ.

Үүнээс хамаагүй өмнө, МЭ 34 онд амилсан Их Эзэн Америк тивд айлчилж байхдаа Өөрийн Сүмийн гишүүдэд адил зааварчилгааг өгсөн. Тэр үед Тэрээр:

“Тиймийн тул та нар сүмийг миний нэрээр нэрлэх болно; . . .

Мөн энэ нь миний нэрээр нэрлэгдэхгүй аваас яахан миний сүм байх билээ? Учир нь хэрэв сүм Мосегийн нэрээр нэрлэгдсэн байвал энэ нь Мосегийн сүм; эсвэл хэрэв энэ нь хүмүүний нэрээр нэрлэгдсэн байвал уг сүм нь хүмүүний сүм байна; харин энэ нь миний нэрээр нэрлэгдвэл, . . . тэгвэл энэ нь миний сүм мөн”⁵ хэмээн хэлсэн.

Тиймээс Сүмийн нэр дээр харилцан тохиролцоо гэж байхгүй юм. Аврагч Өөрийнх нь Сүм ямар нэрээр нэрлэгдэх ёстойг тодорхой хэлэхдээ, тэр ч бүү хэл Тэрээр тунхаглалаа “миний сүм ийн . . . нэрлэгдэх ёстой” хэмээн эхэлснээрээ үүнд нухацтай хандаж байв. Хэрэв бид хочилсон нэрүүдийг хэрэглэх эсвэл хүлээн зөвшөөрөх эсвэл бүр тэдгээр хочилсон нэрийг өөрсдөө дэмжвэл Тэр гомдох болно.

Нэрэнд учир байна уу эсвэл энэ тохиолдолд хочилсон нэрэнд учир байна уу? “ХҮГ Сүм,” “Мормоны Сүм” эсвэл “Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм” зэрэг Сүмийн хочилсон нэрүүдийг авч үзвэл хамгийн содон тод дутагдал бол Аврагчийн нэр эдгээр нэрэнд *байхгүй байгаа* явдал билээ. Их Эзэний Сүмээс Их Эзэний нэрийг авч хаях нь Сатаны томоохон яалт юм. Бид Аврагчийн нэрийг *хэрэглэхгүй* байснаар Есүс Христийн бидний төлөө хийсэн бүхнийг, тэр тусмаа Түүний Цагаатгалыг өөрийн эрхгүй *үл тоодог*.

Үүнийг Түүний алсын хараагаар бодоод үзье. Тэрээр мөнх бус байдлын өмнөх амьдралд Хуучин Гэрээний Бурхан, Иехова байсан. Тэр Эцэгийнхээ удирдлаган доор энэ болон бусад дэлхийн Бүтээгч байсан.⁶ Тэрээр Эцэгийнхээ хүсэлд захирагдаж, өөр хэн ч хийж чадахгүй зүйлийг Бурханы бүх хүүхдэд зориулан хийхийг сонгожээ. Тэрээр алдар суугаа орхин, Эцэгийн Төрсөн Ганц Хүү болон дэлхий дээр махбодтой болж ирээд, балмадаар доромжлуулж, басамжлуулж, нудимуулж, ташуурдуулсан билээ. Гетсеманийн цэцэрлэгт Аврагч маань *бүхий л* өвчин, гэм нүглийг мөн та нарын төдийгүй миний, түүнчлэн амьдарч байсан эсвээс амьдрах бүгдийн *хэзээ нэгэн цагт* мэдрэх *бүх* зовлон зүдгүүр, шаналлыг Өөртөө авсан. Улам бүр шаналган зовоох ачаанаас болж Түүний сүв бүрээс цус шүүрсэн билээ.⁷ Энэ бүх зовлон

шаналаал Түүнийг Калваригийн загалмай дээр харгисаар цовдлогдох үед улам гаарсан.

Эдгээр шаналант тохиолдлоор буюу Түүний хэмжээлшгүй Цагаатгалаар дамжуулан Тэр мөнх амийг бүгдэд өгч, наманчлах нөхцөлтэйгөөр бидний хүн тус бүрийг гэм нүглийн нөлөөллөөс гэтэлгэсэн юм.

Аврагчийг амилсны дараа болон Түүний төлөөлөгчдийг нас барсны дараа дэлхий олон арван жилийн турш харанхуйд автав. Тэгээд 1820 онд Бурхан Эцэг Өөрийн Хүү Есүс Христийн хамт бошиглогч Иосеф Смитэд үзэгдсэнээр Их Эзэний Сүмийн сэргээлт эхэлсэн.

Түүний тэвчсэн бүгдийн дараа, Түүний хүн төрөлхтний төлөө хийсэн бүгдийн дараа бид Их Эзэний сэргээгдсэн Сүмийг өөрөөр нэрлэх бүрдээ Есүс Христийн ариун нэрийг хассаныг мөн үүнийг санаандгүй байдлаар үг дуугүй хүлээн зөвшөөрснийг олж мэдээд, би ихэд халаглалаа.

Ням гараг бүр бид ариун ёслолоос зохистойгоор хүртэхдээ Тэнгэрлэг Эцэгт Түүний Хүү Есүс Христийн нэрийг өөрсөд дээрээ авах хүсэлтэй байгаагаа гэрчилсэн ариун амаалтаа шинэчилдэг.⁸ Бид Түүнийг дагаж, наманчилж мөн зарлигуудыг нь дагаж, *ургэлж* Түүнийг санана гэж амладаг.

Бид Их Эзэний нэрийг Түүний Сүмээс хассанаар *Түүнийг* амьдралынхаа гол хэсгээс санамсаргүй авч хаяагүй байгаа?

Аврагчийн нэрийг өөрсөд дээрээ авах гэдэг нь бусдад үйл хөдлөл, үг хэлээрээ Есүс бол Христ гэдгийг тунхаглаж, гэрчлэхийг хэлдэг. Бид Өөрийнх нь нэрээр нэрлэгдсэн Түүний Сүмийн нэрэнд Аврагчаа *хамгаалж* чадаагүй атлаа биднийг “мормончууд” хэмээн дуудах хэн нэгнийг гомдоохоосоо тэглээ айж байна уу?

Хэрэв хувь хүн болон хүмүүс бид биднийг цэвэршүүлэх, эдгээх, хүчирхэгжүүлэх, өсгөн нэмэгдүүлэх, цаашлаад биднийг өргөмжлөх Есүс Христийн Цагаатгалын хүчинд нэвтрэн орох ёстой бол Түүнийг тэр хүчний эх сурвалж гэдгийг маш тодорхой хүлээн зөвшөөрөх ёстой. Бид Түүний Сүмийг зарлигласан нэрээр нь нэрлэснээр үүнийг эхэлж чадна.

Дэлхийнхний ихэнхийн хувьд, Их Эзэний Сүм одоогоор “Мормоны Сүм” гэдгээр харагддаг. Гэвч Их Эзэний Сүмийн гишүүд бидний хувьд тэргүүнд нь хэн зогсдогийг мэднэ. Есүс Христ Өөрөө зогсдог. Харамсалтай нь, *Мормон* хэмээх нэр томъёог сонссон олон хүн биднийг Мормоныг шүтдэг гэж боддог. Тийм биш! Бид тэр Америкийн эртний агуу бошиглогчийг хүндэтгэн дээдэлдэг.⁹ Харин бид Мормоны шавь нар биш. Бид бол Их Эзэний шавь нар.

Сүм сэргээгдсэн эхний өдрүүдэд *Мормоны Сүм* болон *мормончууд*¹⁰ гэдэг нэр томъёо эдгээр хожмын өдөр Есүс Христийн Сүмийн сэргээлт дэх Бурханы мутрыг оргүй алга болгох зорилгоор хэлсэн харгис болоод доромжилсон нэр томъёоны зүйрлэл байсан юм.¹¹

Ах, эгч нар аа, Сүмийн зөв нэрийг сэргээхийг эсэргүүцсэн дэлхийн тайлбар дүгнэлт их бий. Бидний амьдарч байгаа цахим ертөнц Их Эзэний Сүмийн тухай мэдээллийг төдийгүй хэрэгтэй мэдээллээ бараг тэр даруй олоход бидэнд тусалдаг хайлтын хэрэгслийг оновчтой болгосон учраас шүүмжлэгчид энэ үед алдааг засах нь ухаалаг бус гэж хэлдэг. Бусад нь бид “мормончууд” болон “Мормоны Сүм” гэдгээрээ нийтэд танигдсан учраас үүнийгээ хамгийн сайн ашиглах ёстой гэж боддог.

Хэрэв энэ нь хүмүүний байгуулсан байгууллагын худалдааны тэмдэгтийн тухай яриа бол эдгээр тайлбар байж болно. Гэвч энэ нь Их Эзэний Сүм тул энэ чухал хэрэгт бид Их Эзэн рүү харж, Түүний зам хүмүүний замаас хэзээд өөр байсан, өөр байдаг, өөр ч байх болно гэдгийг хүлээн зөвшөөрдөг. Хэрэв бид тэвчээртэй байж, өөрсдийн хийх зүйлийг сайн хийвэл Их Эзэн биднийг энэ чухал даалгаврыг гүйцэтгэхэд удирдах болно. Эцсийн эцэст, Их Эзэн Нифайд далайг гатлан гарах усан онгоц барихад нь тусалсан шиг Түүний хүслийг эрэлхийлдэг тэдгээр хүнд тусалдгийг бид мэднэ.¹²

Бид эдгээр алдааг засахаар хичээхдээ еелдэг бөгөөд тэвчээртэй байхыг хүсэх болно. Хариуцлага бүхий мэдээллийн хэрэгслүүд бидний хүсэлтэд хариулахдаа уриалгахан хандах болно.

Өмнөх Ерөнхий чуулгануудын нэгэнд ахлагч Бенжамин Де Хоёс ийм нэгэн тохиолдлын тухай ярьсан. Тэрээр “Хэдэн жилийн өмнө [хамтрагч бид хоёрыг] Мексик дэх Сүмийн олон нийттэй харилцах албанд үйлчилж байхад радиогийн нэвтрүүлэгт ярилцлага өгөхийг урьсан юм. . . . [Нэвтрүүлгийн найруулагчдын нэг] [биднээс] ‘Танай сүм яагаад ийм урт нэртэй байдаг юм бэ?’ . . . гэж асуулаа.

[Хамтрагч бид хоёр] энэ асуултыг тавьсанд баяртай байлаа. Сүмийн нэрийг ямар нэгэн хүн сонгоогүй, харин Аврагч өгсөн . . . хэмээн . . . бид тайлбарласан юм. Нэвтрүүлгийн найруулагч тэр даруй еелдгээр ‘Бид энэ нэрийг хүндэтгэлтэйгээр хэлэх болно’ гэлээ”¹³ гэж өгүүлсэн.

Энэ тайлан загвар болж байна. Олон жилийн турш хүлээн зөвшөөрөгдсөн алдаануудыг аажмаар нэг нэгээр нь зөв болгоход хувь хүний зүгээс хамгийн сайн хичээл зүтгэл шаардагдана.¹⁴ Дэлхийн бусад хүн бидний зөв нэрээр нэрлэж дуудахыг маань дагаж эсвэл дагахгүй ч байж мэднэ. Гэвч хэрэв дэлхийн ихэнх хүн Сүмийг болон түүний гишүүдийг буруу нэрлээд, бид мөн адил ингэж нэрлэдэг бол сэтгэлээр унах нь бидний хувьд шударга бус байх болно.

Үүнд манай шинэчлэгдсэн загварын удирдамж тус болно. Энд дурдсанаар “Сүмийн нэрийг хамгийн эхэнд дурдахдаа ‘Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм’ гэсэн бүтэн нэрийг ашиглах нь зүйтэй. Товчлох [хоёр дахь] шаардлага гарвал ‘Сүм’ юм уу ‘Есүс Христийн Сүм’ гэдэг нэрийг ашиглаж болно. Түүнчлэн ‘Есүс Христийн сэргээгдсэн Сүм’ гэдэг нэрийг хэрэглэх нь зөв зүйтэй бөгөөд үүнийг дэмжинэ.”¹⁵

Хэрэв хэн нэг нь “Та Мормон уу?” гэж асуувал та “Хэрэв та намайг Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүн үү гэж асууж байгаа бол тийм ээ би мөн!” гэж хариулж болно.

Хэрэв “Та хожмын үеийн гэгээнтэн үү?”¹⁶ гэж хэн нэг нь асуувал та “Тийм ээ, би мөн! Би Есүс Христэд итгэдэг бөгөөд Түүний сэргээгдсэн Сүмийн гишүүн” хэмээн хариулж болно.

Хүндэт ах, эгч нар минь, Их Эзэний Сүмийн зөв нэрийг сэргээхийн тулд бид хамгийн сайнаараа хичээвэл, мөн Түүний Сүм болохоор Тэрээр хожмын үеийн гэгээнтнүүдийн¹⁷ тэргүүн дээр урьд өмнө хэзээ ч үзэгдэж байгаагүйгээр Өөрийн хүч, адислалуудыг асгах болно гэдгийг би амлая. Бид Есүс Христийн сэргээгдсэн сайн мэдээний адислалуудыг үндэстэн, ястан, хэлтэн мөн хүмүүс болгонд хүргэж, Их Эзэний Хоёр дахь ирэлтэд дэлхийг бэлдэхэд туслах Бурханы тухай мэдлэгтэй мөн хүчтэй байх болно.

Тиймээс, нэрэнд юу оршино вэ? Хариулт нь юу вэ гэвэл, Их Эзэний Сүмийн нэрэнд “Бүх зүйл!” орших болно. Есүс Христ Сүмийг Өөрийнхөө нэрээр нэрлэхэд биднийг чиглүүлж удирдсан, учир нь энэ бол Түүний хүчээр дүүргэгдсэн Түүний Сүм юм.

Бурхан амьдыг би мэднэ. Есүс бол Христ. Тэр өнөөдөр Өөрийн Сүмийг удирддаг. Би энэ бүхнийг Есүс Христийн нэрээр гэрчилж байна, амен.

ЭШЛЭЛҮҮД

1. “Их Эзэн Өөрийн Сүмийн төлөө буюу Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн төлөө илчилсэн нэр хэчнээн чухал болохыг оюун санаанд минь ойгуулан мэдрүүлсэн юм. Бид өөрсдийн зүгээс Түүний хүсэлд нийцүүлэх ажлыг хийх хэрэгтэй байна. Сүүлийн долоо хоногуудад Сүмийн янз бүрийн алба хэлтэс болон удирдагчид энэ ажлыг гүйцэтгэхийн тулд шаардлагатай арга хэмжээг авч эхлээд байгаа билээ. Ирэх саруудад энэ чухал асуудлын талаарх нэмэлт мэдээллүүдийг өгөх болно. (Рассэлл М.Нэлсон “Сүмийн нэр” [албан мэдэгдэл, 2018 оны 8-р сарын 16], mormonnewsroom.org.)
2. Сүмийн өмнөх ерөнхийлөгчид үүнтэй адил хүсэлтүүдийг гаргаж байсан. Жишээлбэл. Ерөнхийлөгч Жорж Алберт Смит “Үүнийг Мормоны Сүм хэмээн нэрлэж, Их Эзэний урмыг бүү хугал. Тэрээр үүнийг Мормоны Сүм хэмээн нэрлээгүй” гэж хэлсэн байдаг (in Conference Report, Apr. 1948, 160–61).
3. “Загварын удирдамж—Сүмийн нэр,” mormonnewsroom.org-оос үзнэ үү.

4. Сургаал ба Гэрээ 115:4
5. 3 Нифай 27:7–8
6. Мосе 1:33-ыг үзнэ үү.
7. Сургаал ба Гэрээ 19:18-ыг үзнэ үү.
8. Моронай 4:3; Сургаал ба Гэрээ 20:37, 77-г үзнэ үү.
9. Мормон бол Мормоны Номыг бичсэн дөрвөн гол зохиогчийн нэг бөгөөд бусад нь Нифай, Иаков, Моронай нар билээ. Мормоны Номын сүнсэлгээр өдөөгдсөн орчуулагч болох бошиглогч Иосеф Смитийн адил тэд бүгд Их Эзэнийг өөрсдийн нүдээр харсан гэрчүүд юм.
10. *Мормончууд* гэдэг үгийг бүр егөөдлийн нэр томъёонд оруулсан байлаа (*History of the Church*, 2:62–63, 126-г үзнэ үү).
11. Бусад зүйрлэл Шинэ Гэрээний үед тохиолдож байсан мэт санагдадаг. Төлөөлөгч Паулыг Феликийн өмнө шүүгдэх үед “Назарын бүлэглэлийн толгойлогч” (Үйлс 24:5) гэж хэлсэн. “Назарын” хэмээх үг хэлэлгийн хэрэглээний талаар нэгэн нэвтрүүлгийн хөтөлгөч “Энэ бол Христэд итгэгчдийг доромжлохдоо өгдөг нэр юм. Есүс Назарынх байсан учраас тэднийг ингэж дууддаг” гэж бичжээ (Albert Barnes, *Notes, Explanatory and Practical, on the Acts of the Apostles* [1937], 313).

Үүнтэй адилаар өөр нэгэн хөтөлгөч “Бидний Их Эзэн дооглон-гүйгаар ‘Назарынх’ гэж нэрлэгддэг байсан шиг” (Матай. ххvi. 71), нудейчүүд шавь нараа мөн ‘Назарынх’ гэх болно. Тэд өөрсдийгөө Христэд итгэгчид, *өөрөөр хэлбэл* Мессиагийн шавь нар гэдгээ хүлээн зөвшөөрөхгүй” гэж мэдэгджээ (*The Pulpit Commentary: The Acts of the Apostles*, ed. H. D. M. Spence and Joseph S. Exell [1884], 2:231).

Үүнтэй холбоотойгоор, ахлагч Нийл А.Максвэлл: “Судрын түүхийн туршид бид бошиглогчдыг хөөхийн тулд нэр төрийг нь гутаахыг мөн тэднийг суруулахын тулд тэдэнд нэр хаяг зүүхийг байн байн оролдож байсныг хардаг. Гэхдээ ихэнхдээ тэднийг тухайн цаг үеийнхнээр нь үл тоомсорлуулж мөн ертөнцийн түүхэнд зүгээр л үл тоомсорлосон. Эцсийн эцэст, эртний Христийн шашинтнуудыг ‘Назарын бүлэглэл’ (Үйлс 24:5) ч гэж бараг дууддаггүй байв. (Үйлс 24:5.)” (“Out of Obscurity,” *Ensign*, Nov. 1984, 10).

12. 1 Нифай 18:1–2-ыг үзнэ үү.
13. Бенжамин Де Хоёс, “Гэгээнтэн гэж дуудагдах нь,” *2011 оны 4-р сарын Ерөнхий чуулган*, 115.
14. Биднийг бусад хүн юу гэж нэрлэн дуудахад бид ямар ч хяналт тавьж чадахгүй ч өөрсдийгөө хэн гэхийг бүрэн дүүрэн хянаж чадна. Бид энэ Сүмийн гишүүдийн хувьд өөрсдөө хийгээгүй байж, Сүмийн зөв нэрийг хүндэтгэхийг бусдаас хэрхэн хүлээж чадах билээ?
15. “Загварын удирдамж – Сүмийн нэр,” mormonnewsroom.org.
16. Ариун хүн гэдэг нэр томъёо Ариун Библид олонтоо хэрэглэгдсэн байдаг. Жишээлбэл, ефесчүүдэд бичсэн Паулын захианд тэр *ариун хүн* гэдэг үгийг бүлэг бүрд дор хаяж нэгийг хэрэглэсэн. Ариун хүн бол Есүс Христэд итгэж, Түүнийг дагахыг хичээдэг хүн юм.
17. Сургаал ба Гэрээ 121:33-ыг үзнэ үү.